



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 87

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтаар хийгдсэн, 30 нэрийн, нийт 1,264,000,000.00 (нэг тэрбум хоёр зуун жаран дөрвөн сая) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Г.Ёндон болон хавсралтад заасан байгууллагын захирал, дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоон бүртгэх, асуудлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системд”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132000295

4-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 22 дугаар сарын 22-ны өдрийн
87 дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН,
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Барилга засварын ажил хүлээн авсан ажлын хэсгийн актын дугаар	Хүлээн авч бүртгэх аймаг, төрийн өмчит байгууллага
1	Сувгийн тэвш л-10	2022	150,079,736.00	01	Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар
2	Сувгийн хучилтын хавтан л-10	2022	113,087,985.00	01	
3	Сувгийн тэвш л-9	2022	89,500,002.00	01	
4	Сувгийн хучилтын хавтан л-9	2022	25,250,001.00	01	
5	Термобазальт дулаалга	2022	96,367,144.00	01	
6	Бөмбөлгөн хаалт ф200	2022	55,320,000.00	01	
7	Ган хоолой ф89х4.0	2022	10,457,250.00	01	
8	Ган хоолой ф159х4.5	2022	30,433,490.00	01	
9	Ган хоолой ф108х4.0	2022	28,312,525.00	01	
10	Ган хоолой ф133х4.0	2022	10,754,852.00	01	
11	Ган хоолой ф219х8.0	2022	75,111,280.00	01	
12	Ган хоолой ф57х3.5	2022	14,914,900.00	01	
13	Ган хоолой ф45х3.0	2022	1,367,600.00	01	
14	Ган хоолой ф76х3.5	2022	16,176,000.00	01	
15	Гулсах тулгуур	2022	8,898,863.00	01	
16	Галын гидрант	2022	13,248,000.00	01	
17	Термобазальт дулаалга	2022	79,934,348.00	01	
18	Худаг	2022	201,564,415.00	01	
19	Үл хөдлөх тулгуур	2022	5,592,365.00	01	
	Дүн		1,026,370,756.00		
20	Сувгийн хучилтын хавтан л-7	2022	27,934,336.00	01	"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК
21	Сувгийн хучилтын хавтан л-9	2022	45,357,500.00	01	
22	Сувгийн хучилтын хавтан л-9	2022	13,613,000.00	01	
23	Сувгийн тэвш л-7	2022	45,863,344.00	01	

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Барилга засварын ажил хүлээн авсан ажлын хэсгийн актын дугаар	Хүлээн авч бүртгэх аймаг, төрийн өмчит байгууллага
24	Сувгийн тэвш л-9	2022	6,906,400.00	01	"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК
25	Сувгийн тэвш л-9	2022	10,151,000.00	01	
26	Ган хоолой ф108х4.0	2022	12,828,565.00	01	
27	Бөмбөлгөн хаалт ф150	2022	15,560,000.00	01	
28	Ган хоолой ф219х4.0	2022	38,966,534.00	01	
29	Ган хоолой ф159х4.5	2022	11,768,565.00	01	
30	Пенополиуретан дулаалга	2022	8,680,000.00	01	
	Дүн		237,629,244.00		
	НИЙТ ДҮН		1,264,000,000.00 (нэг тэрбум хоёр зуун жаран дөрвөн сая)		